

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Шивээговь сумын 3 дугаар сургууль”-ийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2021/22/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойр хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543156

Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 70543179

Цахим хаяг: nananbayarg@audit.gov.mn

Аудитор, нягтлан бодогч С.Батцэцэг

Утас: 70543179

Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжүүлэх сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал.....	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	21
4. Менежментийн захидал.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: govsumber@audit.gov.mn

**ШИВЭЭГОВЬ СУМЫН 3 ДУГААР
СУРГУУЛИЙН ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ Б.ЭНХРИЙМАА ТАНАА**

2021.02.25 № 44

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Шивээговь сумын 3 дугаар сургууль”-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Шивээговь сумын 3 дугаар сургууль”-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 66 арга хэмжээ төлөвлөж бүрэн хэрэгжүүлж ажилласан ба аймгийн ТЕЗ-аас гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 88.5%-тай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

000020154

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,363,063.15	106,491,637.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	16,436,210.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	16,436,210.00
3121	Төгрөг	-	16,436,210.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	16,436,210.00
33	АВЛАГА	5,424,619.65	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	72,418.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,981,650.00	-
335	Бусад авлага	1,370,551.65	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,370,551.65	-
35	БАРАА МАТЕРИАЛ	53,988,443.50	90,055,427.74
351	Түүхий эд материал	-	1,256,500.00
35130	Эм боох материал	-	1,256,500.00
354	Хангамжийн материал	53,988,443.50	88,798,927.74
35410	Бичиг хэргийн материал	426,900.00	344,900.00
35420	Аж ахуйн материал	46,121,223.50	71,014,237.74
35440	Түлш, шатах тослох материал	-	585,560.00
35450	Барилгын засварын материал	3,660,000.00	15,904,030.00
35460	Хүнсний материал	3,780,320.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	950,200.00
36	НӨӨЦИЙН БАРАА	22,950,000.00	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	22,950,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	758,855,017.70	883,509,289.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	758,855,017.70	883,509,289.08
392	Биет хөрөнгө	678,195,017.70	802,574,289.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,144,737,496.65	1,357,734,274.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(669,057,847.92)	(784,346,581.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,195,397.00	100,505,946.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(74,745,957.71)	(9,683,099.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	78,501,759.75	120,011,446.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,904,758.08)	(25,775,457.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	212,996,778.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	(62,766,010.51)	-
39217	Ном	24,238,160.52	44,127,760.52
393	Биет бус хөрөнгө	80,660,000.00	80,935,000.00
39301	Програм хангамж	800,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(800,000.00)	(25,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	80,660,000.00	80,660,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	841,218,080.85	990,000,926.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,081,783.65	14,790.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,081,783.65	14,790.00
413	Өглөг	1,081,783.65	14,790.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,081,783.65	14,790.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	840,136,297.20	989,986,136.82
51	Засгийн газрын хувь оролцоо	840,136,297.20	989,986,136.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	440,894,278.52	440,894,278.52

51101	Өмч: - төрийн	440,894,278.52	440,894,278.52
512	Хуримтлагдсан үр дүн	(320,255,050.19)	(170,405,210.57)
51210	Өмнөх үеийн үр дүн	(320,255,050.19)	(320,255,050.19)
51220	Тайлант үеийн үр дүн	-	149,849,839.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	719,497,068.87	719,497,068.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>841,218,080.85</u>	<u>990,000,926.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,041,659,500.00	1,329,526,492.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	838,451,800.00	217,195,892.51
120	Нийтлэг татварын бус орлого	12,547,400.00	217,195,892.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,547,400.00	18,426,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	18,426,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,547,400.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		163,816,078.27
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		34,953,814.24
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	825,904,400.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	825,904,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,207,700.00	1,112,330,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	975,772,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	975,772,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,190,200.00	3,659,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,333,900.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,856,300.00	3,659,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,017,500.00	132,898,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,017,500.00	132,898,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,040,781,065.12	1,179,676,652.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,040,781,065.12	1,179,676,652.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,030,979,253.75	1,120,230,310.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	671,756,506.88	797,855,614.30
210101	Үндсэн цалин	671,666,824.88	797,855,614.30
210102	Нэмэгдэл	89,682.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,382,162.06	96,601,268.00
210201	Тэтгэврийн даатгал	58,649,275.06	66,751,566.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,716,692.00	7,852,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,329,832.00	6,258,721.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,244,216.00	1,429,980.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,442,147.00	14,308,201.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,591,167.73	120,861,665.14
210301	Гэрэл, цахилгаан	7,773,599.73	6,883,345.14
210302	Түлш, халаалт	112,654,760.00	107,365,280.00
210303	Цэвэр, бохир ус	14,162,808.00	6,613,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,830,346.20	11,932,369.00
210401	Бичиг хэрэг	7,239,400.00	5,707,170.00
210402	Тээвэр, шатахуун	2,700,000.00	2,190,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	345,209.00	539,979.00
210404	Ном, хэвлэл	1,341,300.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	110,000.00	120,000.00

"Шивээговь сумын 3 дугаар сургууль"-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,094,437.20	3,375,180.00
2105	Нормативт зардал	16,834,890.00	8,736,327.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,330.00	2,634,300.00
210502	Хоол, хүнс	16,626,560.00	6,102,027.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	109,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,082,975.00	9,327,520.00
210604	Урсгал засвар	7,082,975.00	9,327,520.00
2107	Томилолт, зочны зардал	364,000.00	2,392,600.00
210702	Дотоод албан томилолт	364,000.00	2,392,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,474,000.00	1,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	902,000.00	1,440,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,000.00	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,663,205.88	70,922,946.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,035,010.00	1,989,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,679,980.00	1,462,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,948,215.88	67,471,156.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,801,811.37	59,446,342.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,718,600.00	25,358,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,581,600.00	21,458,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,137,000.00	3,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,609,300.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,609,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,357.27	734.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,357.27	734.86
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,854.10	30,477,607.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,854.10	30,477,607.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	878,434.88	149,849,839.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,399,453.39	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,399,453.39	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,399,453.39)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(521,018.51)	149,849,839.62

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,029,112,100.00	1,134,738,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	825,904,400.00	18,426,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	18,426,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	18,426,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	18,426,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	825,904,400.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	825,904,400.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,207,700.00	1,116,312,250.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	975,772,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	975,772,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,190,200.00	7,640,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,333,900.00	3,981,650.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,856,300.00	3,659,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,017,500.00	132,898,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,017,500.00	132,898,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,021,631,180.00	1,117,846,590.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,021,631,180.00	1,117,846,590.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	978,319,968.63	1,062,009,547.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	674,864,789.41	786,939,806.30
210101	Үндсэн цалин	645,324,670.41	582,475,351.96
210102	Нэмэгдэл	29,540,119.00	117,349,527.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,906,796.00
210104	Урамшуулал	-	78,208,130.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,444,882.49	107,141,100.00
210201	Тэтгэврийн даатгал	79,768,982.49	77,230,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	669,000.00	5,747,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	535,200.00	6,195,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	133,800.00	1,633,500.00

210205	Эрүүл мэндийн даатгал	1,337,900.00	16,333,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,161,167.73	120,861,665.14
210301	Гэрэл, цахилгаан	7,773,599.73	6,883,345.14
210302	Түлш, халаалт	112,654,760.00	107,365,280.00
210303	Цэвэр, бохир ус	15,732,808.00	6,613,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,467,809.00	14,267,429.00
210401	Бичиг хэрэг	2,499,700.00	670,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,700,000.00	2,775,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	345,209.00	539,979.00
210404	Ном, хэвлэл	3,738,200.00	3,753,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,014,700.00	6,288,000.00
2105	Нормативт зардал	14,777,915.00	3,742,807.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	223,330.00	500,000.00
210502	Хоол, хүнс	13,391,235.00	2,321,707.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,163,350.00	921,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,584,975.00	12,036,500.00
210602	Тавилга	22,730,000.00	-
210604	Урсгал засвар	5,854,975.00	12,036,500.00
2107	Томилолт, зочны зардал	364,000.00	2,392,600.00
210702	Дотоод албан томилолт	364,000.00	2,392,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,067,000.00	5,966,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,583,000.00	4,306,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	902,000.00	1,440,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,587,430.00	8,660,840.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	515,000.00	1,989,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,072,430.00	6,671,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,311,211.37	55,837,042.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,228,000.00	25,358,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,091,000.00	21,458,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,137,000.00	3,900,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,357.27	734.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,357.27	734.86
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	81,854.10	30,477,607.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,854.10	30,477,607.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,480,920.00	16,891,660.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,480,920.00	455,450.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,480,920.00	455,450.00

2200	Дотоод эх үүсвэрээр	7,480,920.00	455,450.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,480,920.00	455,450.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,480,920.00)</u>	<u>(455,450.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	16,436,210.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	16,436,210.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	440,894,278.52	719,497,068.87	-323,715,681.68	836,675,665.71
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	440,894,278.52	719,497,068.87	-323,715,681.68	836,675,665.71
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,460,631.49	3,460,631.49
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	440,894,278.52	719,497,068.87	-320,255,050.19	840,136,297.20
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	440,894,278.52	719,497,068.87	-320,255,050.19	840,136,297.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	440,894,278.52	719,497,068.87	-320,255,050.19	840,136,297.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	149,849,839.62	149,849,839.62
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	440,894,278.52	719,497,068.87	-170,405,210.57	989,986,136.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,108,671,300.00	1,078,192,957.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,108,671,300.00	1,078,192,957.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,069,329,400.00	1,052,834,257.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	786,949,600.00	786,939,806.30
210101	Үндсэн цалин	625,657,100.00	582,475,351.96
210102	Нэмэгдэл	93,713,100.00	117,349,527.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,412,500.00	8,906,796.00
210104	Урамшуулал	57,166,900.00	78,208,130.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,141,100.00	107,141,100.00
210201	Тэтгэврийн даатгал	74,474,600.00	77,230,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,166,500.00	5,747,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,533,200.00	6,195,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,633,500.00	1,633,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,333,300.00	16,333,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,862,400.00	120,861,665.14
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	6,883,345.14
210302	Түлш, халаалт	106,062,400.00	107,365,280.00
210303	Цэвэр, бохир ус	7,800,000.00	6,613,040.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	10,763,600.00	10,763,579.00
210401	Бичиг хэрэг	670,000.00	670,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,775,600.00	2,775,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540,000.00	539,979.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,238,000.00	6,238,000.00
2105	Нормативт зардал	20,227,400.00	3,742,807.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	500,000.00
210502	Хоол, хүнс	18,806,300.00	2,321,707.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	921,100.00	921,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,036,500.00	12,036,500.00
210604	Урсгал засвар	12,036,500.00	12,036,500.00
2107	Томилолт, зочны зардал	357,600.00	357,600.00
210702	Дотоод албан томилолт	357,600.00	357,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,966,800.00	5,966,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,306,800.00	4,306,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,440,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,024,400.00	5,024,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,024,400.00	5,024,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,341,900.00	25,358,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,341,900.00	25,358,700.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,441,900.00	21,458,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	3,900,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,108,671,300.00	1,078,192,222.58
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	975,772,400.00	945,294,057.44
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	975,772,400.00	945,294,057.44
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	132,898,900.00	132,898,165.14
122005	Орон нутгийн төсвөөс	132,898,900.00	132,898,165.14
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	56.50	56.50
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	41.50	41.50
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	738.00	738.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	738.00	738.00
630001	Төрийн өмчит ЕБС	738.00	738.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,630,740.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,630,740.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,630,740.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,659,300.00
210404	Ном, хэвлэл	3,609,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,035,000.00
210702	Дотоод албан томилолт	2,035,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,936,440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,989,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,946,650.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,640,950.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,640,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,609,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,031,650.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Шивээговь сумын 3 дугаар сургууль”-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Б.Энхриймаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгадагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгадагч этгээдэд цахим төлбөрийн баримтад хяналт тавих, талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар”-ын аудитор, нягтлан бодогч С.Батцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

“Шивээговь сумын 3 дугаар сургууль” 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар”-т 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Шивээговь сумын 3 дугаар сургууль”-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уламжлал ёс заншил, өв соёлоо дээдлэн хүндэлдэг, зөв монгол хүнийг төлөвшүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант онд 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Б/18 тушаалаар Пүрэвийн Ариунааг нягтлан бодогчоор томилсон байна.

Тайлант хугацаанд сургуулийн захирал Буяндэлгэр жирэмсэн амаржсаны амралтаа авсан тул захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2020 оны 11 сарын 12-ны өдрөөс Б.Энхриймааг томилсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Шивээговь сумын 3 дугаар сургууль” нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Санхүү, хяналт, аудитын албанаас 2020 онд шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчилгүй гэж үзсэн байна.

Говьсүмбэр аймгийн “Шивээговь сумын 3 дугаар сургууль”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 03 дугаар улирлын орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлын 938,332.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,384.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,179,676.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,796.8 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Шивээговь сумын 3 дугаар сургууль”-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 148,782.8 мянган төгрөгөөр буюу 17.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансанд тус тус материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
	1	2	3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	16,436.2	16,436.2
Авлага	5,424.6	0.00	-5,424.6
Бараа материал	53,988.4	90,055.4	36,067.0
Бусад эргэлтийн хөрөнгө	22,950.0	0.00	-22,950.0
Үндсэн хөрөнгө	758,855.0	883,509.3	124,654.3
Нийт хөрөнгө	841,218.1	990,000.9	148,782.8
Өр төлбөр	1,081.8	14.8	-1,067.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	840,136.3	989,986.1	149,849.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	841,218.1	990,000.9	148,782.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 16,436.2 мянган төгрөг нь шинээр ахмадын сан байгуулснаас үүссэн байна.

Авлагын дансны өмнөх оны 5,424.6 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 90,055.4 мянган төгрөг болж 36,067.0 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 1,256.5 мянга, аж ахуйн материал 24,893.0, шатах тослох материал 585.6 мянга, барилгын материал 12,244 мянга, бусад хангамжийн материал 950.2 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бусад эргэлтийн хөрөнгө данс 22,950.0 мянган төгрөгөөр буурч үлдэгдэлгүй тайлагнасан нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 883,509.3 мянган төгрөг болж 124,654.3 мянган төгрөгөөр өссөн нь хандив болон үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.
ГСА-2021/22/СТА-ТШЗ

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн худалдан авалтаар 455.4 мянга, БСШУЯ-аас 27,941.5 мянга, ОНХС-аас 27,977.3 мянга, Иргэдийн хандив 18000.0 мянга, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 89,897.3 мянга, бараа материал болон нөөцийн хөрөнгөөс 27,853.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

АИТХ-ын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 42 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан 23,018.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан. АИТХ-ын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 35 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан боловч дахин үнэлсэн 89,897.3 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 14.8 мянган төгрөг болж буурсан нь ажиллагсадтай холбоотой өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 989,986.1 мянган төгрөг болж 149,849.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

“Шивээговь сумын 3 дугаар сургууль”-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,329,526.5 мянган төгрөг болж өмнөх оноос 287,867.0 мянган төгрөгөөр буюу 27.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого нь ахмадын сангийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө болон бараа материал, цалин, НДШ зардалтай холбоотой нэмэгдсэнээс тус тус шалтгаалсан байна.

Нийт зардал 138,895.5 мянган төгрөг болж өмнөх оноос 13.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ, урсгал засвар, дотоод томилолт, төрөөс иргэд олгох тэтгэмж, урамшуулал зэрэг зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлттэй холбоотой залруулга хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,006,630.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,006,630.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 189,799.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,196,430.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс их хэмжээгээр нэмэгдүүлж баталсан нь цалин хөлс, НДШ, дотуур байрны хүүхдийн хоол, төрөөс иргэд олгох тэтгэмж, урамшууллыг зардлуудыг өмнөх оноос нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 /Ерөнхий боловсрол/ хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,196,430.0 мянган төгрөгийн төсөв баталснаас тайлант хугацаанд 5 удаа төсвийн хуваарьт өөрчлөлт орж, төсвийн тодотголоор 87,758.7 мянган төгрөгөөр хасагдаж, 1,108,671.3 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ. Төсвийн тодотгол хийгдсэн бөгөөд цалин хөлс, НДШ, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, дотуур байрны хоол, төрөөс иргэд олгох тэтгэмж, урамшууллын зардлуудыг бууруулсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,108,671.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,078,193.0 мянган төгрөгийг зарцуулж, 30,478.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,078,193.0 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалин хөлс 9.8 мянга, гэрэл цахилгааны зардлыг 0.7 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 16,484.6 мянга, төрөөс иргэнд олгох тэтгэмж, урамшуулал зардлыг 13,983.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг дутуу зарцуулсан нь 71802 хөтөлбөрийн 5 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч 30,478.3 мянган төгрөгийн бодит хэмнэлт гарсан нь Ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор үйл ажиллагаа явуулаагүйгээс дотуур байрны хүүхдийн хоол болон төрөөс иргэд олгох тэтгэмж, урамшууллын зардлууд хэмнэгдсэн, мөн төсвийг төсөвлөснөөс үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн хуваарилсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлогоор Түрээсийн номын орлого 3,609.3 мянган төгрөг, өөрийн байрны түрээсийн орлого 50.0 мянган төгрөг, өмнөх оны нэмэлт дансны орлого 3,981.6 мянган төгрөгийн орлогыг бүртгэсэн бөгөөд түрээсийн номын төлбөр 3,609.3 мянган төгрөгийг СБТТогтолцоо-Эргэлтийн санд төвлөрүүлж, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 50.0 мянга, дотоод томилолтын зардалд 2,035.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 1,989.8 мянга, хичээл үйлдвэрлэлийн зардалд 1,946.6 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 116 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 31 мэдээлэл байна.

Шилэн дансны хуудсанд байршуулсан мэдээллийг мөнгөн гүйлгээ болон анхан шатны баримт материалтай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийг сар, улирал бүр оруулахад 2,7,10,11-р сарууд болон 3-р улиралд хугацаа хоцроож мэдээлсэн.
2. Тухай жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг 1,5,6,7,8,9,10-р саруудад хугацаа хоцроож оруулсан.
3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, шийдвэрийн хуулбарыг /тухай бүр/ 1,6-р саруудад хугацаа хоцроож мэдээлсэн.
4. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концесын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг /бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр/ 7-р сард хугацаа хоцроож мэдээлсэн.

5. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг /тухай бүр/ 1,5-р саруудад хугацаа хоцроож мэдээлсэн
6. 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг /тухай бүр/ 1,5,6-р саруудад хугацаа хоцроож мэдээлсэн
7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл /тухай бүр/ 1,5-р саруудад хугацаа хоцроож мэдээлсэн
8. Бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 1,5-р саруудад хугацаа хоцроосон бөгөөд 9 тушаалыг оруулаагүй байна.
9. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /тухай бүр/ 1-р сард хугацаа хоцроож оруулсан.
10. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /сар бүр/ 7,8,9,10,11-р саруудад хугацаа хоцроож оруулсан.
11. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг 1 сард хугацаа хоцроож оруулсан.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 237,511.8 мянган төгрөг илэрснээс зөрчлийг арилгуулах 235,946.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна. 1,565.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт барагдуулсан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн актын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	235,946.8	3	235,946.8	1	0	-
Төлбөрийн акт	1	1,565.0	1	1,565.0			
Нийт дүн	4	237,511.8	4	237,511.8	1	0	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 244,832.4 мянган төгрөгийн 18 алдаа, зөрчил илэрснээс 141,122.9 мянган төгрөгийн 10 алдааг аудитын явцад залруулж, 13,392.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 90,317.3 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 104,759.7 мянган төгрөгийн 8 зөрчлийг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсний дагуу залруулсан ба 36,363.2 мянган төгрөгийн 2 зөрчлийг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. НДШ-ийн тайлан дутуу тайлагнасан 178.1 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

2. ХХОАТ-ын тайланд дутуу тайлагнасан 148.8 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.
3. Сургалтын менежер, багш нарт ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон 785.8 мянган төгрөгийн залруулсан.
4. Мөрдөгдөж эхлээгүй тушаалаар багш нарт нэмэгдэл олгосон 312.1 мянган төгрөгийг залруулсан.
5. Цалингийн зардлын дансны бичилтийг давхардуулан бичсэн 719.7 мянган төгрөгийг залруулсан.
6. БСШУЯ, БСУГ-аас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн хөрөнгийг бараа материалын тодруулга тайланд хандиваар бүртгэсэн 4,970.0 мянган төгрөгийг залруулсан.
7. БСШУЯ, БСУГ-аас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд хандиваар бүртгэсэн 57,275.1 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.
8. Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 40,370.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.
9. Бараа материалыг хооронд шилжүүлснийг буруу тайлагнаж орлогоор бүртгэсэн 32,753.9 мянган төгрөгийг залруулсан.
10. Санхүүгийн үр дүнгийн тайланд номын түрээсийн төлбөрийг төвлөрүүлэх шилжүүлгээр тайлагнаагүй 3,609.3 мянган төгрөгийг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй 103,709.6 мянган төгрөгийн 7 зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

